



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 07/03

Эрдэнэт


**“Аялал жуулчлалыг хөгжүүлэх”
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 18.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Ээлжит II хуралдааны 02/02 дугаар тогтоолоор баталсан “Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 6 дугаар бүлгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг нэгдүгээр хавсралт, хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр баталж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусгах арга хэмжээг авч, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

079130008

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02
дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII хуралдааны
02/03 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ОРХОН АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Бодлого боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр “Аялал жуулчлалын тухай хууль” (2000), “Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого” (2014-2030), “Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” (2020-2024), “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (2016-2025), “Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого” (2019-2026) зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг батлан амжилттай хэрэгжүүлж байна. Орхон аймгийн хувьд дээрх бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зургаа дугаар бүлгийн аялал жуулчлалын бодлогыг үндэслэл болгосон.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд орон нутгийн нөөц боломжид тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар тодорхой зорилтууд тусгагдсан нь тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна. Тиймээс тус аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхийн тулд энэхүү “Орхон аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсрууллаа.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр аймгийн аялал жуулчлалын хөгжлийг олон улсын аялал жуулчлалын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэх, Орхон аймгийн онцлогт нийцсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, брэнд бий болгон өрсөлдөх чадварыг сайжруулах, зорин ирэх жуулчдын тоог өсгөх, аймгийн эдийн засгийг төрөлжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх зэрэг эерэг үр дүн гарах юм.

Хоёр. Бодлогын хамрах хүрээ

Орхон аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг тус аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх бөгөөд хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Бүх шатны төрийн байгууллага;
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
3. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага;
4. Иргэний нийгмийн байгууллага болон төрийн бус байгууллага;
5. Иргэд

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх зарчим

Орхон аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийг дараах зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1 Үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;

3.1.1 Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;

- 3.1.2 Нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 3.1.3 Тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
- 3.1.4 Тэнцвэртэй байх;
- 3.1.5 Нөөц эх үүсвэрт үндэслэсэн байх;
- 3.1.6 Ил тод, нээлттэй байх;
- 3.1.7 Судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 3.1.8 Зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
- 3.1.9 Шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
- 3.1.10 Төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
- 3.1.11 Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
- 3.1.12 Бүх талын оролцоог хангасан байх;
- 3.1.13 Төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
- 3.1.14 Оролцогчдын хариуцлагын зарчим;

Дөрөв. Хөтөлбөрийн алсын хараа, зорилго, зорилт

4.1. Алсын хараа

Монгол улс дахь “хотын аялал жуулчлалын жишиг төв” болно.

4.2. Зорилго

Орхон аймгийн онцлогт тохируулан хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

4.3. Зорилт

- 4.3.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг, үйлчилгээг уялдуулан менежментийг сайжруулна.
- 4.3.2 Орхон аймгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, орон зайн төлөвлөлт хийнэ.
- 4.3.3 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдлыг сайжруулан өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, иргэдийн тогтвортой аялал жуулчлалын мэдлэгийг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 4.3.4 Орхон аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, сургалт, сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Хөтөлбөрийг 2022-2025 онуудад 1 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг, үйлчилгээг уялдуулах, тогтвортой хөгжилд суурилсан эко технологийг

нэвтрүүлэх, аймгийн нөөц боломжид тулгуурласан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, брэнд бүтээгдэхүүн бий болгох, маркетинг, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Хөтөлбөрийг 2025 оноос хойш үргэлжлэхээр тооцоолсон.

Зургаа. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дараах чиглэлд тулгуурлан хэрэгжүүлнэ.

6.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг боловсруулж төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг, үйлчилгээг уялдуулан менежментийг сайжруулна.

- 6.1.1 Аялал жуулчлалын үйл ажиллагааны хөгжлийн бодлого төлөвлөлт, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд зөвлөн туслах чиг үүрэг бүхий 9 хүний (аялал жуулчлалын бизнес эрхлэгч 2 хүн, эрдэмтэн судлаач 2 хүн, төрийн байгууллагын 3, аялал жуулчлалын мэргэжлийн төрийн бус байгууллагын 2 төлөөлөл) бүрэлдэхүүнтэй Аялал Жуулчлалын Зөвлөлийг Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулах.
- 6.1.2 Эрдэнэт хотод бизнес, ажил хэрэг (MICE), эвент, спорт, уул уурхайд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- 6.1.3 Эрдэнэт хотын аялал жуулчлалын онцлогийг илэрхийлсэн соёл урлаг, спорт, адал явдалт аялал, энтертайнмэнт шоу арга хэмжээ, үзэсгэлэнг бодлогоор дэмжих
- 6.1.4 Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, төсөл, хөтөлбөрүүдийг олон улсын болон үндэсний байгууллагуудад танилцуулж дэмжлэг авах, бүтээн байгуулалтын томоохон төслийг хэрэгжүүлэхийг бодлогоор дэмжих.
- 6.1.5 Эрдэнэт хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ-ийг боловсруулж хэрэгжүүлэх.
- 6.1.6 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үйл ажиллагаа явуулах, ногоон гэрчилгээ авахад нь дэмжлэг үзүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, сурталчлах.
- 6.1.7 Олон улсын болон дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлж, хотоо сурталчлах.
- 6.1.8 Орхон аймгийг зорин ирж буй болон дайран өнгөрч буй жуулчдын судалгааг жуулчны үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан нарийвчлан гаргадаг механизмыг бүрдүүлэх, хотын аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгох
- 6.1.9 Орон нутгаас аялал жуулчлалын талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад салбарын мэргэжилтэн, эрдэмтэн судлаач, мэргэжлийн төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, тэдний санал, санаачлагыг дэмжих.
- 6.1.10 Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагууд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг хангах

- 6.1.11 Их шүтээн, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, Ёс заншлын өргөөг түшиглэн аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах, аялал жуулчлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх.
- 6.1.12 Орон нутгийн онцлогийг харуулсан гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн (зэс сувинер, зэс медалион, хивс, гар урлалын зүйлс г.м) үйлдвэрлэгчдийг дэмжих, орон нутгийн иргэд аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг нэмэгдүүлэх
- 6.2 Орхон аймгийн онцлогт тулгуурласан аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, орон зайн төлөвлөлт хийнэ.**
- 6.2.1 Сархиа уулын орчимд экстрим спортыг хөгжүүлэх дэд бүтцийг бий болгох (спорт авиралт, мөсөнд авиралтын хана болон экстрим, адал явдалт аяллын бусад байгууламжууд)
- 6.2.2 Аялал жуулчлалын “Зэсэн Эрдэнийн гудамж”-ийг байгуулах
- 6.2.3 Аялал жуулчлалын энтертаймэнт шоу фестиваль, эвентийг бий болгож дэд бүтцийг хөгжүүлэх
- 6.2.4 Эрдэнэт хотын онцлогийг илэрхийлсэн “Copper Festival” эвент арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх
- 6.2.5 Орхон аймгийн адал явдалт аялал болон Эрдэнэт хотын аялал жуулчлалын маршрутыг боловсруулж, батлуулах
- 6.2.6 Орхон аймгийн хилийг тойрсон “Эрдэнэт марафон” гүйлтийн тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулах
- 6.2.7 Сархиа, Баян-Өндөр ууланд праглайдингийн агаарын аялал, Эрдэнэт-үсгэн лого, сурталчилгаа чөлөөт цагийн дэлгэц, явган алхалт, дугуйн зам байгуулж, зам, жимийг тохижуулах, амрах сандал, эко ариун цэврийн байгууламж, мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулах.
- 6.2.8 Эрдэнэт хотын угтах хаалга орчимд “Welcome Erdenet” угтах, үдэх цогцолборыг батлагдсан зураг төслийн дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, дамжин өнгөрч буй болон зорин ирж буй аялагч, жуулчдыг QR кодоор E- Erdenet порталд бүртгэж жуулчдын тоо, статистикийг гаргах.
- 6.2.9 Жаргалант сумын нутаг Айргийн гозгорт байрлах Эртний булш хиргисүүрүүд дэх малтлага судалгааны ажлыг дотоодын болон гадаадын судалгаа, өвийн байгууллагуудтай хамтран эрчимжүүлж, түүнд түшиглэсэн ил музей байгуулах төслийг боловсруулах.
- 6.2.10 “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран үйлдвэрийн орчны бүсэд геотуризмын (уул уурхай) сэдэвт хүрээлэнг байгуулах төслийг эхлүүлэх.
- 6.2.11 Орон нутагт нисдэг тэрэг буух боломжтой нисэх буух зурвас байгуулах (нисдэг тэрэг, бага оврын нисэх онгоцоор ирэх бизнес, ажил хэргийн жуулчдыг хүлээн авах)
- 6.2.12 Аялал жуулчлалын гол чиглэл дагуу авто замын сүлжээг сайжруулах, замын тэмдэг, тэмдэглэгээг нутгийн бэлгэ тэмдэг болох зэсээр нэгдсэн стандартын дагуу хийж бий болгох
- 6.2.13 Эрдэнэт хот руу тусгай хөтөлбөр бүхий галт тэрэгний аяллын брэнд бий болгох
- 6.2.14 18-ын карьерыг түшиглэн орон нутгийн оршин суугчдын амралт зугаалгын бүс байгуулах төслийг эхлүүлэх. (эко байдлаар тохижуулж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах)

- 6.2.15 Ахан дүүсийн найрамдалт холбоотой улс орон, хотуудтай хамтарсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчин солилцох.
- 6.2.16 Дотоод, гадаадын жуулчдад зориулсан Эрдэнэт хотын аялал жуулчлалын гар утасны аппликейшн, вэб сайтыг бий болгох, жуулчдын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бүртгэлийн систем бий болгож E- Erdenet порталтай холбох.
- 6.2.17 Олон улсын хурал зөвлөгөөн, уулзалт семинар, ажил хэргийн зорилгоор ирсэн зочид, жуулчдад үйлчлэх боломжтой 4-5 од бүхий зочид буудлыг байгуулах
- 6.2.18 Олон улсын стандартад нийцсэн дээд зэрэглэлийн зоогийн газруудыг байгуулах, өөр хоорондоо ялгарахуйц дүр төрх, онцлог бүхий зоогийн болон уушийн газруудыг бий болгох.
- 6.2.19 Жаргалант суманд мал аж ахуйд суурилсан нүүдлийн соёлын аялал жуулчлал, газар тариалан, фермерийн аж ахуйд суурилсан агро аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэх.

6.3 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдлыг сайжруулан өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, иргэдийн тогтвортой аялал жуулчлалын мэдлэгийг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.

- 6.3.1 Гадаад, дотоодын жуулчдын ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх
- 6.3.2 Аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, удирдлагын ур чадварыг сайжруулах чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах.
- 6.3.3 Орхон аймгийн МСҮТ-дэд түшиглэн аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэх, багшлах боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах, сургалтын стандарт хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх.
- 6.3.4 “Аялал жуулчлалын хүний нөөцийн мэдээллийн сан”-г бүрдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээний системийг бий болгож E- Erdenet порталтай холбох.
- 6.3.5 Амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бүх нийтийн экологи, аялал жуулчлалын боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг Орхон аймгийн иргэдэд үе шаттайгаар зохион байгуулах.
- 6.3.6 Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулж гадаад, дотоодын жуулчдад зориулсан хөтөлбөр боловсруулж, брэнд урлагийн тоглолт, арга хэмжээ тогтмол зохион байгуулах.
- 6.3.7 Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа бизнес эрхлэгчдэд аялал жуулчлалын салбараас орлого олох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийн талаар сургалт явуулж, ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэх.

6.4 Орхон аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, сургалт, сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.

- 6.4.1 Орхон аймгийн аялал жуулчлалын сурталчилгаа, маркетингийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.
- 6.4.2 Зорилтот зах зээл (залуучууд, экстрим спорт сонирхогчид, олон улсын болон дотоодын хурал зөвлөгөөн, соёл, спортын наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн яармаг зохион байгуулагчид, оролцогчид) рүү чиглэсэн маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх.

- 6.4.3 Орхон аймгийн онцлог, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилсан контент бүтээх.
- 6.4.4 Орхон аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад болон дотоодод нэр хүндтэй хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах, олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.
- 6.4.5 Гадаад, дотоодын түнш хотуудтай хамтран аялал жуулчлалын өдөрлөгийг жил бүр зохион байгуулж, хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

-o0o-

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн Ээлжит VII хуралдааны 07/03 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин

№	Зорилго, зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь		Зорилто т түвшин	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
				ОН	Түв-шин			
<p>Зорилго: Орхон аймгийн онцлолт тохируулан хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p>								
<p>Зорилт 1: Аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг боловсруулж төрийн байгууллага хоорондын болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиг үүрэг, үйлчилгээг уялдуулан менежментийг сайжруулна.</p>								
1.	Аялал Жуулчлалын Зөвлөлийг Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулах	Байгуулагдсан эсэх	тоо	2021	0	1	ХБТХОХ БОАЖГ	АЖЗБЭХолбоо
1.1.	Эрдэнэт хотод бизнес, ажил хэрэг (MICE), эвент, спорт, уул уурхайд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Төлөвлөгөө боловсруулсан эсэх	Төлөвлөгөө ний тоо	2021	0	5	ХБТХОХ НБХ	БОАЖГ “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
1.2.	Эрдэнэт хотын аялал жуулчлалын онцлогийг илэрхийлсэн соёл урлаг, спорт, адал явдалт аялал, энтертайммент шоу арга хэмжээ, үзэсгэлэнг бодлогоор дэмжих	Дэмжлэг үзүүлсэн эсэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2021	-	6	ХБТХОХ НБХ Аймгийн АЖ-ын Зөвлөл	БОАЖГ АЖЗБЭХолбоо
1.3.	Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, төсөл, хөтөлбөрүүдийг олон улсын болон үндэсний байгууллагуудад танилцуулж дэмжлэг авах, бүтээн байгуулалтын томоохон төслийг хэрэгжүүлэхийг бодлогоор дэмжих.	Хэрэгжүүлсэн төсөл	Төслийн тоо	2021	-	5	ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл, МУХАУТ	БОАЖГ

1.5.	Эрдэнэт хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх томоохон төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ-ийг боловсруулж хэрэгжүүлэх	Боловсруулсан ТЭЗҮ	ТЭЗҮ-ийн тоо	2021	1	5	ХБТХОХ БОАЖГ	Аялал жуулчлалын мэргэжлийн судлаачид
1.6.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчдийг тогтвортой аялал жуулчлалын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үйл ажиллагаа явуулах, ногоон гэрчилгээ авахад нь дэмжлэг үзүүлэх	Ногоон гэрчилгээжилт	Байгууллагын тоо	2021	0	10	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	МУХАУТ АЖЗБЭХолбоо
1.7.	Олон улсын болон дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлж, хотоо сурталчлах	Үзэсгэлэн, хамтын ажиллагаа	Тоо	2021	2	12	ХБТХОХ БОАЖГ	Аймгийн АЖ-ын Зөвлөл АЖЗБЭХолбоо
1.8.	Орхон аймгийг зорин ирж буй болон дайран өнгөрч буй жуулчдын судалгааг жуулчны үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан нарийвчлан гаргадаг механизмыг бүрдүүлэх, хотын аялал жуулчлалын мэдээллийн санг бий болгох	Механизм бүрдүүлж, жуулчдын тоог нарийвчлан гаргасан эсэх	Жуулчдын тоо, хувь	2019	Дот оод 27,4 34 Гадаад 4,000 ад 422		ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо Статистикийн хэлтэс
1.9.	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад салбарын мэргэжилтэн, эрдэмтэн судлаач, мэргэжлийн төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах, тэдний санал, санаачлагыг дэмжих	Хамтран ажилласан эсэх	Хамтын ажиллагааны гэрээний тоо	2021	1	30	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо АЖБХН ТББ
1.10.	Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагууд болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс үзүүлэх дэмжлэг, хөнгөлөлтөд хамруулах нөхцөлийг хангах	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хувь өссөн эсэх	Хувиар	2021	-	10	ХОХБТХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо МУХАУТ Сумдын ЗДТГ
1.11.	Их шүтээн, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, Ёс заншлын өргөөг түшиглэн аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах, аялал жуулчлалын үр өгөөжийг нэмэгдүүлэх.	Байгууламжуудын менежмент сайжирсан эсэх	Менежментийн төлөвлөгөөний тоо	2021	-	3	ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл БОАЖГ	АЖЗБЭХолбоо Сумдын ЗДТГ
1.12.	Орон нутгийн онцлогийг харуулсан гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	ЖДҮ-ийг хөгжүүлэх	төгрөг	2021	19,4 тэрб			АЖЗБЭХолбоо ХХААГ

	үйлдвэрлэгчдийг дэмжих, орон нутгийн иргэд аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг нэмэгдүүлэх	чиглэлээр авсан төслийн санхүүжилт		ум төг	23 тэрбум	ХБТХОХ, БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	Сумдын ЗДТГ
2.	Зорилт 2: Орхон аймгийн онцлог тулгуурласан аялал жуулчлалын өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг бий болгох, дэд бүтцийг хөгжүүлэх, орон зайн төлөвлөлт хийнэ.						
2.1.	Сархиа уулын орчимд экстрим спортыг хөгжүүлэх дэд бүтцийг бий болгох (спорт авиралт, мөсөнд авиралтын хана болон экстрим ба адал явдалт аяллын бусад байгууламжууд)	Дэд бүтцийн хөгжил	Бүтээн байгуулалтын тоо	0	6	ХБТХОХ НБХ БОАЖГ	Аймгийн АЖ-ын Зөвлөл Хувийн хэвшил
2.2.	Аялал жуулчлалын "Зэсэн Эрдэнийн гудамж" байгуулах	Үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо өссөн эсэх	Тоо	-	40000	ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил	БОАЖГ АЖЗБЭХолбоо
2.3.	Аялал жуулчлалын энтертайнмент шоу фестивал, эвентыг бий болгох дэд бүтцийг хөгжүүлэх	Үйл ажиллагааны тогтвортой байдал	Шоу, эвент үйл ажиллагааны тоо	-	2	ХБТХОХ БОАЖГ НБХ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо, хувийн хэвшил
2.4.	Эрдэнэт хотын онцлогийг илэрхийлсэн "Copper Festival" эвент арга хэмжээг зохион байгуулах, хөгжүүлэх	Зохион байгуулалт, хөгжүүлэлт	Оролцогчдын тоо	-	3000 (үүнээс гадаад 500)	ХБТХОХ БОАЖГ НБХ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо, АЖБХН, хувийн хэвшил
2.5.	Орхон аймгийн адал явдалт аялал болон Эрдэнэт хотын аялал жуулчлалын маршрутыг боловсруулж, батлуулах	Маршрутыг боловсруулсан эсэх	Боловсруулж, батлуулсан маршрутын тоо	-	6	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖБХН АЖЗБЭХолбоо
2.6.	Орхон аймгийн хилийг тойрсон "Эрдэнэт марафон" гүйлтийн тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулах	Зохион байгуулсан эсэх	Оролцогчдын тоо	-	250	ХБТХОХ НБХ БОАЖГ	Аймгийн АЖ-ын Зөвлөл, АЖЗБЭХолбоо

2.7.	Сархиа, Баян-Өндөр ууланд праглайдингийн агаарын аялал, Эрдэнэт-үсгэн лого, сурталчилгаа чөлөөт цагийн дэлгэц, явган алхалт, дугуйн зам байгуулж, зам, жимийг тохижуулах, амрах саңдал, эко ариун цэврийн байгууламж, мэдээллийн самбар, тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулах.	Хотын иргэдийн дугуйн болон явган алхалт хийх хувь	Аялагч, алхагчдын тоо	2019	160-170	6000	ХБТХОХ НБХ БОАЖГ	Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил
2.8.	Эрдэнэт хотын утгах хаалга орчимд "Welcome Erdene" утгах, үдэх цогцолборыг батлагдсан зураг төслийн дагуу төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулж, дамжин өнгөрч буй болон зорин ирж буй аялагч, жуулчдыг QR кодоор E-Erdene порталд бүртгэж жуулчдын тоо, статистикийг гаргах.	Байгуулагдсан эсэх	Тоо	2021	0	1	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил Сумдын ЗДТГ	АЖЗБЭХолбоо Статистикийн хэлтэс Авто тээврийн төв
2.9.	Жаргалант сумын нутаг Айргийн гозгорт байрлах Эртний булш хиргисүүрүүд дэх малтлага судалгааны ажлыг дотоодын болон гадаадын судалгаа, өвийн байгууллагуудтай хамтран эрчимжүүлж, түүнд түшиглэсэн ил музей байгуулах төслийг боловсруулах.	Малтлага судалгаа хийгдэж, ил музей байгуулагдсан эсэх	Малтлагын тоо, Бүтээн байгуулалтын тоо	2021	0	Ил музей:1	ХБТХОХ НБХ Аймгийн АЖ-ын Зөвлөл, ШУА-ийн Археологийн хүрээлэн	БОАЖГ Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ Хувийн хэвшил
2.10.	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-тай хамтран үйлдвэрийн орчны бүсэд геотуризмын (уул уурхай) сэдэвт хүрээлэнг байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлэх	Байгуулагдсан эсэх, үзэгчдийн тоо	Бүтээн байгуулалтын тоо	2021	-	20000	ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	БОАЖГ АЖЗБЭХолбоо ТББ
2.11.	Орон нутагт нисдэг тэрэг буух боломжтой нисэх буух зурвас байгуулах (нисдэг тэрэг, нисэх онгоцоор ирэх бизнес, ажил хэргийн жуулчдыг хүлээн авах)	Нисэх буух зурвас	Тоо	2021	-	1	ХБТХОХ, Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил	БОАЖГ
2.12.	Аялал жуулчлалын гол чиглэл дагуу авто замын сүлжээг сайжруулах, замын тэмдэг, тэмдэглэгээг нутгийн бэлгэ тэмдэг болох	Авто замын урт, чанар, тэмдэг	Авто замын урт, сайжруулахын зассан	2021	-	-	ХБТХОХ, Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил	Сумдын ЗДТГ Авто тээврийн төв

	зэсээр нэгдсэн стандартын дагуу хийж бий болгох	Хөтөлбөр боловсруулан батлаж хэрэгжүүлсэн эсэх	урт, тэмдэг тэмдэглэгэ эний хувь							
2.13.	Эрдэнэт хот руу тусгай хөтөлбөр бүхий галт тэрэгний аяллын брэнд бий болгох	Хөтөлбөр боловсруулан батлаж хэрэгжүүлсэн эсэх	Галт тэрэгний аяллын аялагчдын тоо	2021	-	1000	ХБТХОХ, Аймгийн АЖ-ын Зөвлөл, АЖЗБЭХолбоо, УБТЗ	БОАЖГ Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ		
2.14.	18-ын карьерыг түшиглэн орон нутгийн оршин суугчдын амралт зугаалгын бүс байгуулах (эко байдлаар тохижуулж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах)	Ил талбайд тарьсан тарьцын тооны өсөлт	Тарьцын тоо	2019	38,800	90,000	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл, хувийн хэвшил	АЖЗБЭХолбоо ТББ-иуд		
2.15.	Ахан дүүсийн найрамдалт холбоотой улс орон, хотуудтай хамтарсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчин солилцох	Аймгийн ДНБ-д эзлэх үйлчилгээний салбарын эзлэх хувь	Хувь	2019	10,9	12	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо Хувийн хэвшил		
2.16.	Дотоод, гадаадын жуулчдад зориулсан Эрдэнэт хотын аялал жуулчлалын гар утасны аппликейшн, вэб сайтыг бий болгох, жуулчдын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бүртгэлийн систем бий болгож E- Egednet порталтай холбох	Жуулчлалын гар утасны аппликейшн, вэб сайт хөгжүүлэлт	Тоо	2021	-	1	ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо Хувийн хэвшил		
2.17.	Олон улсын хурал зөвлөгөөн, уулзалт семинар, ажил хэргийн зорилгоор ирсэн зочид, жуулчдад үйлчлэх боломжтой 4-5 од бүхий зочид буудлыг байгуулах	Аймгийн зочид буудлын тоо, өрөөний тоо	Бүтээн байгуулалтын тоо, Орны тоо	2019	Зочид буудал 35, Ор 25, Ор 603		ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл	БОАЖГ АЖЗБЭХолбоо Хувийн хэвшил		
2.18.	Олон улсын стандартад нийцсэн дээд зэрэглэлийн зоогийн газруудыг байгуулах, өөр хоорондоо ялгарахуйц дүр төрх, онцлог бүхий зоогийн болон уушийн газруудыг бий болгох	Аймгийн зоогийн газрын тоо	Тоо	2019	160	220	ХБТХОХ Аймгийн АЖ-ын Зөвлөл Хувийн хэвшил	БОАЖГ ХХААГ Сумдын ЗДТГ АЖЗБЭХолбоо		

2.19.	Жаргалант суманд мал аж ахуйд суурилсан нүүдлийн соёлын аялал жуулчлал, газар тариалан, фермерийн аж ахуйд суурилсан агро аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэх	Аялал жуулчлалын төрлүүдийн хөгжлийн түвшин	Аялал жуулчлалын оролцогч тал болсон айл өрхийн тоо	2021	-	20	ХБТХОХ Жаргалант сумын ЗДТГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	Малчид, фермерүүд, нутгийн иргэд Хувийн хэвшил	
3.	Зорилт 3: Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, стандарт, аюулгүй байдлыг сайжруулан өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, иргэдийн тогтвортой аялал жуулчлалын мэдлэгийг дээшлүүлэн ажлын байрыг нэмэгдүүлнэ.								
3.1.	Гадаад, дотоодын жуулчдын ая тухтай, аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх	Гэмт хэргийн тоо буурсан эсэх	Тоо	2019	747	477	ХБТХОХ БОАЖГ ХЭЗХ	АЖЗБЭХолбоо Хувийн хэвшил	
3.2.	Аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, удирдлагын ур чадварыг сайжруулах чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах	Аймгийн АЖ-ын салбарта ажиллагсадын тоо нэмэгдсэн эсэх	Тоо	2019	1745	2513	ХБТХОХ мэргэжлийн багш судлаачид	БОАЖГ АЖЗБЭХолбоо	
3.3.	Орхон аймгийн МСҮТ-дэд түшиглэн аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэх, багшлах боловсон хүчнийг бэлтгэх, чадавхжуулах.	МСҮТ-д суралцаж буй суралцагчдын тоо өссөн эсэх	Тоо	2019	868	1250	ХБТХОХ БШУГ БОАЖГ	ХХУГ, МСҮТ АЖЗБЭХолбоо	
3.4.	"Аялал жуулчлалын хүний нөөцийн мэдээллийн сан"-г бүрдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээний системийг бий болгож E-Egdenet порталтай холбох	Мэдээллийн сан болон үнэлгээний систем бий болгох	Тоо хэмжээ	2019	0	1	ХБТХОХ БОАЖГ	АЖЗБЭХолбоо	
3.5.	Амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, бүх нийтийн аялал жуулчлалын боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг Орхон аймгийн иргэдэд үе шаттайгаар зохион байгуулах	Сургалт, сурталчилгааны ажлын тоо	Тоо	2019	0	5	ХБТХОХ БОАЖГ	АЖЗБЭХолбоо ГБХЗГ Сумдын ЗДТГ	
3.6.	Соёлын биет бус өвийг өвчлөн уламжлагчдыг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулж гадаад, дотоодын жуулчдад зориулсан хөтөлбөр боловсруулж, брэнд	Дотоод, гадаадын жуулчдын тоо өссөн байдал	Тоо	2019	Дотоодын жуулчдын тоо 27434 Гадаадын жуулчдын тоо 4,000	Дотоод 40,000 Гадаад 4,000	ХБТХОХ НБХ БОАЖГ	БСУГ Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ АЖЗБЭХолбоо	

	урлагийн тоглолт, арга хэмжээ тогтмол зохион байгуулах.					дын 422 жуулчин			
3.7.	Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа бизнес эрхлэгчдэд аялал жуулчлалын салбараас орлого олох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийн талаар сургалт явуулж, ажлын байр бий болгох нөхцөлийг бүрдүүлэх.	Шинээр бий болсон зочид буудал, зоогийн газрын ажлын байрны тоо өссөн байдал	Тоо хэмжээ	2019	451	649	ХБТХОХ БОАЖГ ХХААГ	ХХҮГ Сумдын ЗДТГ	
4.	Зорилт 4:Орхон аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, сургалт, сурталчилгаа, маркетингийн ажлыг эрчимжүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.								
4.1.	Орхон аймгийн аялал жуулчлалын сурталчилгаа, маркетингийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	Гадаад, дотоодын жуулчдын тоо өссөн байдлаар	Тоо	2019	Дотоодын 27434 жуулчин гадаадын 422 жуулчин	Дотоод 40,000 Гадаад 4,000	ХБТХОХ, БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл	АЖЗБЭХолбоо Хувийн хэвшил ТББ-иуд	
4.2.	Зорилтот зах зээл (залуучууд, экстрим спорт сонирхогчид, олон улсын болон дотоодын хурал зөвлөгөөн, соёл, спортын наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн яармаг зохион байгуулагчид, оролцогчид) рүү чиглэсэн маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх						ХБТХОХ БОАЖГ НБХ		
4.3.	Орхон аймгийн тухай аялал жуулчлалын сурталчилгааны дүрс бичлэг, зурган контент бүтээх						ХБТХОХ, БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл		
4.4.	Орхон аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад болон дотоод нэр хүндтэй хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилах, олон нийтийн сүлжээнд суурилсан цахим сурталчлагааны ажлыг эрчимжүүлэх						ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл		
4.5.	Гадаад дотоодын түнш хотуудтай хамтран аялал жуулчлалын өдөрлөгийг жил бүр зохион байгуулж, хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх						ХБТХОХ БОАЖГ Аймгийн АЖ-ын Зөвлөл		